

Газар хөдлөлтийн гамшгийн үед
онцгой байдлын ерөнхий газрын
бие бүрэлдэхүүний ажиллах
төлөвлөгөөний 3 дугаар
хавсралт

Шуурхай удирдлагын штабын гүйцэтгэх үйл ажиллагаа

- Газар хөдлөлтийн гамшгийн үеийн ажлыг төлөвлөх хэрэгжүүлэх, шуурхай бүлгийн бүрэлдэхүүний үйл ажиллагааг удирдах,
- Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эмзэг байдал, эрсдлийн үнэлгээ хийлгэх,
- Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тодотгох,
- Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалахтай холбогдолтой бүх төрлийн судалгаа гаргах,
- Шуурхай удирдлагын штабын болон шуурхай бүлгийн бүрэлдэхүүнд гамшгаас хамгаалах сургалт, дадлага зохион байгуулах,
- Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах зориулалтын аврах багаж хэрэгслээр хангах, бэлэн байдлыг хангуулах,
- Газар хөдлөлтийн гамшгийн цагийн байдлын талаар мэдээлэл цуглуулах,
- Хохирлын үнэлгээ хийх,
- Гамшгийн голомтод аврах ажлыг гүйцэтгэх, мэргэжлийн анги, бүлгийг ажиллах нөхцлөөр хангах,
- Гамшгийн үед хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах,
- Харилцан ажиллагааг зохион байгуулах.

Холбоо, зарлан мэдээллийн хэсэг

- Газар хөдлөлтийн гамшгийн үеийн бүх төрлийн холбоо, зарлан мэдээллийн үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах,
- Холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах,
- Газар хөдлөлтийн гамшгийн цагийн байдлын талаарх мэдээг цаг алдалгүй хүлээн авах, мэдээлэх, удирдлагыг тасралтгүй холбоогоор хангах,
- Байгууллагын хэмжээнд зарлан мэдээлэл дамжуулах бүдүүвч боловсруулах, дадлага сургуулиар бодит байдлыг шалгах

Хангалт үйлчилгээний хэсэг

- Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах шуурхай удирдлагын штабын болон шуурхай бүлгийн бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэх чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх,
- Гамшгийн хор уршгийг арилгахад шаардлагатай багаж хэрэгсэл, шатах тослох материал, хоол хүнс, эм тариа, хувцас, бусад бараа материалын нөөцийг бүрдүүлэх,
- Төрийн болон хувийн өмчийн машин техникийн судалгаа гаргах,
- Аврах ажлын зориулалттай багаж хэрэгслийг засварлах, бэлэн байдлыг хангуулах,
- Нүүлгэн шилжүүлэх бэлтгэл хангах, түр амьдрах байр, хүнс, эмнэлгийн хангалтыг зохион байгуулах,
- Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж буй бүрэлдэхүүний хангалтыг зохион байгуулах,
- Шаардлагатай бараа, материалын жагсаалт гарган, бүрдүүлэх.

Олон нийттэй харилцах хэсэг:

- Шаардлагатай мэргэжлийн анги, бүлгийг байгуулах талаар удирдлагад санал гаргах, байгуулах шийдвэр гаргуулах,
- Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах сургалт дадлагад хамруулах,
- Томилгоот бүрэлдэхүүний нөхөн хангалтыг хийх, хүний нөөцийн судалгаа хийх,
- Газар хөдлөлтийн гамшгийн голомтод мэргэжлийн удирдлагаар хангах,
- Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалахтай холбогдолтой хууль тогтоомжийг сурталчлах, урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх ажлыг зохион байгуулах,
- Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах сургалт, дадлага сургуулийг удирдан зохион байгуулах,
- Газар хөдлөлтийн гамшгийн нөхцөл байдал, хор уршгийн талаар тайлбарлан таниулах ажлыг хийх,
- Гамшгаас хамгаалах сургалт, дадлага сургуульд шаардлагатай танхим, дадлагын талбайг бэлтгэх тохижуулах,
- Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас сэрэмжлүүлэх сурталчилгааны материал бэлтгэх, хангах.